

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын
“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан
өвчнөөс урьдчилан сэргийлэх арга
хэмжээг зохион байгуулах байгууллагыг
сонгох журам”-ын хавсралт 2

Ажил гүйцэтгэх гэрээ

20... оны ... сарын ...-... өдөр

Багануур дүүрэг

- 1.1 Энэхүү гэрээг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу сонгогдсон байгууллагатай Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 06 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/74 дүгээр тушаал түүний хавсралтыг үндэслэж Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар рд: 9103538 хуулийн дагуу төлөөлж дарга Р.Өнөржаргал цаашид (Захиалагч), нөгөө төлөөсХХК-ийн хуулийн дагуу төлөөлж захиралцаашид (Ажил гүйцэтгэгч) хамтад нь (талууд) гэх Иргэний хуулийн 343 дугаар зүйлийг удирдлага болгон харилцан тохиролцож байгуулав.

Нэг: Ерөнхий нөцхөл

- 1.1 Гэрээнд гүйцэтгэх ажил: Захиалагчийн оршин буй бүс нутгийн жижиг, дунд үйлдвэрт ажиллагсад, үйлдвэрийн газар, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид, бичил уурхай эрхлэгч, шатахуун түгээх газруудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу цахимаар болон уулзалтаар зохион байгуулах.
- 1.1.1 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой гарын авлага, хууль тогтоомжийн сурталчилгааг сургалтад оролцогчдод хүргэж, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх.
- 1.1.2 Тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэн сурталчлах.
- 1.1.3 Сургалтад оролцогчдоос “Сэтгэл ханамжийн судалгаа” авч үр дүнг дараагийн сургалтын үйл ажиллагаанд тусгаж ажиллах.
- 1.1.4 Эрсдэл өндөртэй үйлдвэр эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд практик болон хууль эрх зүйн сургалтыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах.
- 1.1.5 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын ач холбогдол, Нийгмийн даатгалын сангаас үзүүлж буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаар ойлголт өгөх, мэдлэг олгох.
- 1.2 Гэрээний санхүүжилт: Нийт төлбөрийг Ажил гүйцэтгэгчийн тоот банкны дансанд шилжүүлнэ.
- 1.2.1 Урьдчилгаа төлбөрийг “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах хүсэлт бүхий албан бичиг, сургалтын хөтөлбөр, арга хэмжээний удирдамж”-ийг үндэслэн төгрөгийг ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаар.
- 1.2.2 Үлдэгдэл төлбөрийг “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт зохион байгуулсан төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн анхан шатны баримтууд, төлбөрийн нэхэмжлэх, арга хэмжээний үр дүнгийн тайлан, хавсралт гуравт

заасан гэрээ дүгнэсэн акт зэргийг үндэслэн төгрөг хүртэл санхүүжилтийг олгоно.

1.2.3 Санхүүжилтийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан”-ийн “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний зардлын төсвөөс санхүүжүүлнэ.

1.3 Гэрээний хугацаа: 2025 оны дугаар сарын ...-ны өдрөөс 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр хүртэл хүчинтэй.

1.3.1 Гэрээнд заасан ажлыг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн дотор гүйцэтгэнэ.

Гурав: Захиалагчийн эрх, үүрэг

3.1 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сургалтыг цахимаар болон танхимаар хамтран зохион байгуулах үүрэгтэй.

3.2 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах явцад хяналт тавих.

3.3 Санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх.

3.4 Захиалагч нь ажил гүйцэтгэгчийн үр дүнгийн болон төсвийн тайланг нэгтгэн үр дүн, саналын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх үүрэгтэй.

3.5 Ажил гүйцэтгэгч гэрээт ажлыг гүйцэтгэхдээ гэрээний нөхцөл, хууль зөрчсөн нь тогтоогдвол гэрээг учирсан хохиролоо шаардах эрхтэй

3.6 Ажил гүйцэтгэгчийн ажлын үр дүн нь илт муу, ажлыг буруу, чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.

3.7 Хууль, тогтоомжид заасан бусад эрх.

Дөрөв: Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Захиалагчаас өгсөн эрх зүйн баримт бичгийн хүрээнд сургалт болон урьдчилан сэргийлэх ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

4.2 Ажил гүйцэтгэгч нь өөрийн ажлыг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

4.3 Гэрээний ажлын гүйцэтгэлийг шударгаар гүйцэтгэх үүрэгтэй.

4.4 Захиалагчаас өгсөн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, зарцуулсан тайланг үнэн зөв гаргаж захиалчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

4.5 Ажил гүйцэтгэгч арга, хэмжээ зохион байгуулж дууссанаас **хойш ажлын 7 өдрийн дотор** төсвийн гүйцэтгэл болон үр дүнгийн тайланг захиалагчид хүргүүлэх үүрэгтэй.

4.5 Захиалагчийн буруугаас санхүүжилт хойшилсон тохиолдолд гүйцэтгэх ажлын хугацааг мөн хугацаагаар хойшлуулах санал гаргах эрхтэй.

4.6 Гэрээний үнийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу шаардах эрхтэй.

4.7 Хууль, тогтоомжид заасан бусад эрх.

Тав: Хариуцлага

5.1 Талууд гэрээ болон хуульд заасан үүргээ зөрчсөн тохиолдолд хохирол учирсан тал гэрээг цуцлах эрхтэй.

5.2 Талуудын хооронд маргаан гарвал эвлэрэлийн журмаар хэлэлцэж, шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.3 Талууд гэрээг хуулийн хувьд ижил гурван хувь үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулна.

Гэрээ байгуулсан:

Захиалагч:

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар рд 9103538

Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 1-р хороо, Нацагдоржын гудамж, 58 тоот

Ажил гүйцэтгэгч:

Утас: 70210021

Газрын дарга: /Р.Өнөржаргал/

Санхүү, бүртгэл хамтралт
орлогын хэлтсийн дарга: /Ц.Солонго/